

Mongolian language for foreigners – Week 12
Lecture №12

Сэдэв: Монголчуудын идээ ундаа
Topic: Foods and drinks of Mongolians

Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх
listening, speaking, reading, writing

Mongolian National University Arts And Culture
Professor, Basbish.S

Хичээлийн агуулга - Lecture content

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монголчуудын идээ, ундаа – Foods and drinks of Mongolians- Meat dishes, Milk products
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework



Admin. (2022, January 9). Монгол хоол хүнс [Photograph]. zarig.mn.
<https://zarig.mn/v2r>

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест – Test

1. Монголчуудын дээл хувцас бол монгол онцлогийг тодорхойлдог хамгийн чухал зүйлсийн нэг юм.
A. Хэлний Б. Үндэстний В. Улсын Г. Орны
2. Монгол үндэсний гол төлөөлөл нь малгай, дээл, бүс, хантааз, гутал юм.
A. Эдлэлийн Б. Чимэг зүүлтний В. Хоолны Г. Хувцасны
3. Монголчууд ихэд хүндэтгэн эрхэмлэж, газар тавих, дээгүүр нь алхах, гишгэхийг цээрлэдэг.
 А. Малгайг Б. Гутлыг В. Өмдийг Г. Ороолтыг
4. Тэгш төрийн хэмээхийн учир нь хүнийг төв шулуун, тэгш намбатай байхыг ерөөж ийнхүү нэрлэжээ.
A. Цамц Б. Хүрэм В. Дээл Г. Майк
5. Бүтэх төрийн нь задгай, тасархайг бэхлэн батжуулах, бутарсныг эвлүүлэхийн утгатай.
A. Ороолт Б. Зүүлт В. Бүс Г. Тэлээ

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

6. Хан төрийнгэдэг нь төр улсын иргэн гэдгийн баталгаа бөгөөд аливаа хүндэтгэл, ёслолд заавал өмсөх өмсгөл юм.

А. Дээл

Б. Хантааз

В. Цамц

Г. Хүрэм

7. Мандах төрийнхэмээхийн учир нь хүнийг шударга, ёстой төртэй, мандан бадарч явахыг бэлгэдсэн байна.

А. Алчуур

Б. Ороолт

В. Малгай

Г. Зүүлт

8. Түших төрийннь хүний биеийн тулгуур болсон хөлийн өмсгөл учраас тулж түших, бат суурьтай явахыг бэлгэдсэн.

А. Малгай

Б. Гутал

В. Өмд

Г. Ороолт

9. Монголчуудын хувцас нь монгол нутагт анхны төрт улсыг байгуулсаннарын хувцаснаас эхлэлтэй.

А. Сяньби

Б. Хүннү

В. Жужан

Г. Түрэг

10.онд хувцасны хууль гаргаж, монгол ван, гүнгүүдийн цол хэргэм, зэрэг дэвийн хувцасны маяг, хэрэглэх зүйлийг тусгайлан заасан байна.

А. 1459

Б. 1559

В. 1659

Г. 1759

Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.

1. Монголчуудын хоол, хүнсэнд ямар бүтээгдэхүүн голлодог вэ?
2. Сүүгээр ямар ямар хоол, цагаан идээ хийдэг вэ?
3. Махаар ямар ямар хоол хийдэг вэ?
4. Монгол хоол идэж үзсэн үү? Таалагдсан уу? Яагаад?

Монголчуудын идээ, ундаа Foods and drinks of Mongolians

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning*

1. Аарц – curd
2. Ааруул-dried curd
3. Айраг – yoghurt made of raw milk
4. Амин дэм - vitamin
5. Ан агнах – to hunt
6. Боловсруулах – to process
7. Бяслаг - cheese
8. Жимс, ургамал түүх – to gather fruit and herb
9. Зөөхий – clotted cream
10. Нэрмэл архи – home-distilled spirits
11. Өрөм – clotted cream
12. Судалгаа явуулах – to carry survey
13. Тааран уут – sackcloth bag
13. Тараг бүрэх – make yoghurt
14. Тариа будаа тарих- to plant grains
15. Хоормог – fermented milk of camel cow
16. Хөөрүүлсэн сүү – boiled milk
17. Цагаан идээ – dairy products
18. Цагаан хоол – meal made of milk
19. Цагаан тос – leftovers after butter has been extracted from clotted milk
20. Цөцгий – soure cream
21. Шар тос - butter
22. Шим тэжээлтэй - nutritious
23. Ээдэм – curded milk
24. Ээзгий – curds cheese

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Milk products

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 55.3, 350, нэрмэл, хоормог,
цагаан хоол, нүүдлийн, с амин дэмээр, таргийг, бяслаг, шар тос*

МОНГОЛЧУУДЫН ИДЭЭ УНДАА

Монголчуудын уламжлалт аж ахуй нь 1) _____ мал аж ахуй учраас эрт дээр үеэс малын сүү, махыг боловсруулж хоол хүнсэндээ хэрэглэсээр ирсэн. Үүний зэрэгцээ ан агнаж, тариа будаа тарьж, байгалийн жимс, ургамал түүн, хоол хүнсэндээ хэрэглэдэг.

1918 онд Монголчуудын дунд судалгаа явуулж, нийт хүнсний бүтээгдэхүүний 2) _____ хувийг сүү, цагаан идээ, 20.3 хувийг мах эзэлж байсныг тогтоожээ.

Судлаач Я. Цэвэл “...Ерөнхийдөө 180 гаруй төрлийн махан хоол, 130 гаруй төрлийн цагаан идээ ба цагаан хоол, 30 гаруй төрлийн боов идээ, бүгд 3) _____ орчим төрлийн монгол хоол байдаг” хэмээн тэмдэглэжээ.

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Milk products

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 55.3, 350, нэрмэл, хоормог,
цагаан хоол, нүүдлийн, с амин дэмээр, таргийг, бяслаг, шар тос*

Сүү, цагаан идээ: Цагаан идээ боловсруулах арга нутаг нутагт өөр өөр. Эдгээрээс тараг, айраг, өрөм, шар тос, цагаан тос, аарц, ааруул, бяслаг, ээзгий, цөцгий, зөөхий, хоормог зэргийг бараг бүх нутагт хийдэг. 4) _____ үхэр, хонь, ямааны хөөрүүлсэн сүүгээр бүрдэг бөгөөд зун цагт ихэвчлэн оройн хоолонд хэрэглэдэг. Зарим нутагт үхэр, хонь, ямааны түүхий сүүг исгэн айраг хийх бөгөөд үүнээс 5) _____ гаргаж авдаг.

Монголчуудын идээ, ундаа Foods and drinks of Mongolians – Milk products



Үнээний сүү

Кальцийн өндөр агууламжтай учир хүний биеийг хэрэгцээт амин дэм, эрдэс бодис, илчлэгээр хангадаг.



Таван хошуу малын сүүний шимт чанар /Адууч/



Гүүний сүү



Цийдмэг сүүний төрөлд хамаардаг, нүүрс ус нэлээд их хэмжээгээр агуулагддаг учир тамиржуулах, бодисын солилцоог дээшлүүлэх, хоол боловсруулалтыг сайжруулах, исэлдэн ангижрах, сэргээх процессыг идэвхжүүлдэг.



Ямааны сүү

Витамин А, В6, кальци, кали, зэсийг ихээр агуулдаг.



Ингэний сүү

Цацраг идэвх туяаны хордлогыг тайлах, эд эсийн нөхөн төлжилтийг идэвхжүүлэх, чийг бам, хаван хөөхөд үр дүнтэй.



Хонины сүү

Амтлаг бүлээн чанартай тул хий дарах, хөлийн бам өвчнийг засах, эмийн хөлөг болгон хэрэглэдэг. Өвчнийг дарна. Зүрхэнд муу учир болгоомжтой хэрэглэх нь зүйтэй.



Таван хошуу мал [Photograph]. (2018, May 11). chuhai.mn.
<http://chuhai.mn/r/33337>

Цагаан идээ [Photograph]. (2011, December 3). mn.wikipedia.org.
https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD_%D0%B8%D0%B4%D1%8D%D1%8D#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Tsgaan_idee_olon.jpg

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Milk products

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 55.3, 350, нэрмэл, хоормог,
цагаан хоол, нүүдлийн, с амин дэмээр, таргийг, бяслаг, шар тос*

Шар тосыг хонины гүзээнд хийж хадгалах бөгөөд голдуу сүүтэй цайнд хийх, арвайн гурил зуурах, боорцог хийх зэргээр хэрэглэдэг. Шар тос нь илчлэг ихтэй учраас өвөл, хаврын улиралд хоол хүнсэндээ ихээхэн хэрэглэдэг бөгөөд эрүүл мэндэд маш тустай.

Шар тосыг нь ялгаж авсан айргаа битүү буцалгаж б) _____ гаргаж авах бөгөөд буцалгасан айргаа хөргөөж, тааран уутанд хийж шүүгээд аарц гаргаж авна.


Монголчуудын идээ, ундаа Foods and drinks of Mongolians – Milk products

Шар тос



Уламжлалт анагаах ухаан сонин. (2022, January 17). Шар тос [Photograph]. www.mnb.mn. <https://www.mnb.mn/i/254560>

Айраг



mn.wikipedia.org. (2017, July 12). Айраг [Photograph]. www.mnb.mn. <https://www.mnb.mn/i/180033>

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Milk products

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: 55.3, 350, нэрмэл, хоормог, цагаан хоол, нүүдлийн, с амин дэмээр, таргийг, бяслаг, шар тос

Аарцаа шахаж, ямар ч шүүсгүй болгосны дараа нарийхан утсаар зүсч, жижиглэн хатаагаад, ааруул болгодог. Намар цаг агаар сэрүүсч, хүйтэрсэн үед аарцыг хурааж хөлдөөгөөд, өвөл, хаврын улиралд буцалгаж уудаг. Буцалгасан аарц 7) _____ баялаг учир ханиаданд маш сайн. Мөн сүүгээ хөөрүүлж хөргөөхөд дээр нь өрөм тогтдог.

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Milk products

***Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words***

***Нөхөх үгс - Choose from following words: 55.3, 350, нэрмэл, хоормог,
цагаан хоол, нүүдлийн, с амин дэмээр, таргийг, бяслаг, шар тос***

Гүүний сүүг исгэн айраг гаргаж авдаг. Айргийг өдөр тутам уухаас гадна найр наадамд эрхэм хүндтэй ундаанд тооцогддог. Харин ингэний сүүг исгэн хоормог гаргаж авна. Ингэний хоормог, гүүний айраг нь калци, бусад аминдэмээр баялаг учраас хүний биед сайн нөлөөтэй. Тийм учраас зарим өвчинд эмчилгээ болгон уудаг. Сүүг мөн исгэж хөөрүүлэн ээдэм, ээдмээ шүүж, шахаж хатаагаад, бяслаг хийдэг.

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Milk products

Хоормог



Mongolian national broadcaster. (2021, April 5). Хоормог [Photograph]. www.mnb.mn.
<https://www.mnb.mn/i/233008>

Бяслаг



Бяслаг [Photograph]. (2011, October 24). mn.wikipedia.org.
https://mn.wikipedia.org/wiki/%D0%91%D1%8F%D1%81%D0%BB%D0%B0%D0%B3#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Cheese_platter.jpg

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians

*Дасгал 3. Дараах үгсийг ашиглан холбоо үг бүтээгээрэй.
Exercise 3. Match following words to its explanation.*

- | | |
|-----------|--------------|
| 1. Тараг | а. Шүүх |
| 2. Сүү | б. Буцалгах |
| 3. Бяслэг | в. Загсаах |
| 4. Айраг | г. Шахах |
| 5. Аарц | д. Бүрэх |
| 6. Ааруул | е. Исгэх |
| 7. Өрөм | ё. Хөөрүүлэх |
| 8. Ээзгий | ж. Зүсэх |

Дасгал 4. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 4. Discuss about following questions and review your understanding

1. Монголчууд яагаад мах, сүүг ихэвчлэн хоол хүнсэндээ хэрэглэдэг вэ?
2. Хичнээн төрлийн монгол хоол байдаг вэ?
3. Сүүгээр ямар ямар бүтээгдэхүүн хийдэг вэ?
4. Таргийг юуны сүүгээр хийдэг вэ?
5. Шар тосыг яаж хийдэг вэ? Ямар ямар хоол хүнсэнд хэрэглэдэг вэ?
6. Аарц, ааруулыг яаж хийдэг вэ? Юунд сайн бэ?
7. Гүүний айраг, ингэний хоормогийг яагаад эмчилгээнд хэрэглэдэг вэ?
8. Бяслагийг яаж хийдэг вэ?

Монголчуудын идээ, ундаа Foods and drinks of Mongolians – Meat dishes

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning*

1. Ан агнуур – hunting
2. Аргаль – Argali, an Asiatic wild sheep with large
3. Борцлох – to dry meat in strips
4. Бөөр – kidney
5. Буга - deer
6. Бүхэл махан хоол – boiled meat by cutting up into joints
7. Гахай -pig
8. Гүзээ - rumen
9. Гөрөөс - antelope
10. Дотор мах – internal organ
11. Зүрх - heart
12. Зээр - gazelle
13. Нөөцлөх - reserve
14. Өвчүү - sternum
1. Хуйхлах – to singe
2. Сэмж - epiploon
3. Тарвага - marmot
4. Толгой - head
5. Туулай - rabbit
6. Улайсгах – to get red hot
7. Урин дулаан цаг – warm season
8. Уушги – lung
15. Үхрийн тагалцаг – pastern bone
16. Шийр – shin
17. Шуузлах – cook meat in its juice
18. Элэг – liver
19. Эрдэс – mineral
20. Янгир – ibex
21. Хандгай - elk

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Meat dishes

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: халуун уураар, ан агнуур, шүүсэнд, дотор, чулуу, борцлох/шуузлах, хярамцаг, хорхог/боодог, бүхэл

Махан хоол: Монголчуудын эрт дээр үеэс эрхэлж ирсэн мал аж ахуй, 8) _____
_____ хоол хүнсний гол эх үүсвэр юм. Намар цагт ангийн мах, өвөл цагт бэлдэж нөөцөлсөн малын мах гол хоол хүнс болдог. Махаар хорхог, боодог, бууз, хуушуур гэх мэт олон төрлийн хоол хийнэ. Махыг жижиглэн чанаж идэх нь элбэг бөгөөд үүнийг бүхэл махан хоол гэдэг.

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Meat dishes

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: халуун уураар, ан агнуур, шүүсэнд, дотор, чулуу, борцлох/шуузлах, хярамцаг, хорхог/боодог, бүхэл

Монголчууд голдуу зээр, гөрөөс, аргаль, янгир, гахай, туулай, тарвага, буга, хандгай агнадаг. Шувуу, загасны махыг бага хэрэглэдэг. Мал болон ангийн 9) _____ махыг ч хоол хүнсэндээ хэрэглэдэг. Ангийн дотор махнаас ихэвчлэн элэг, сэмж, бөөр, зүрхийг нь, харин малын гэдэс дотрыг бүгдийг нь цэвэрлэн чанаж иднэ. Уушги, гүзээ хоёрыг борцолж, бусад хоолны хольц болгоно.

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Meat dishes

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: халуун уураар, ан агнуур, шүүсэнд, дотор, чулуу, борцлох/шуузлах, хярамцаг, хорхог/боодог, бүхэл

Өвөл идэш бэлдэх үед үхэр болон бог малын цусыг бөөр, зүрх, элэг, уушги, дотор өөх зэрэгтэй хольж гүзээнд нь хийж хөлдөөнө. Үүнийг 10) _____ гэх бөгөөд шөлтэй хоол, хуурга хийдэг. Малын толгой, шийрээр ч мөн хоол хийдэг. Тухайлбал, хонь, ямааны толгой, шийр, өвчүү, сүүл, үхрийн тагалцгийг арьстай нь аваад үсийг нь хуйхалж угаагаад чанаж иднэ. Малын дотор мах, толгой, шийр нь эрдэс, аминдэмээр баялаг учир Монголчуудын аминдэмээ нөхөх гол хоол хүнс нь болдог байжээ.

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Meat dishes

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: халуун уураар, ан агнуур, шүүсэнд,
дотор, чулуу, борцлох/шуузлах, хярамцаг, хорхог/боодог, бүхэл*

Махыг удаан хадгалах гол арга нь хатааж 11) _____, _____ юм. Үхэр, хонь, ямаа, тэмээний махыг өвөл борцлон хатааж, урин дулаан цагт иднэ. Махыг зөөлөн галаар өөрийнх нь шүүсэнд болгож, шүүсийг маханд нь шингээн ширгээж битүү саванд агаар оруулахгүйгээр нягт дарж хадгалдаг. Үүнийг шууз гэнэ. Шуузаар бүх төрлийн хоол хийнэ.

Монголчуудын идээ, ундаа Foods and drinks of Mongolians – Meat dishes

Мах хадгалах арга, борц, шууз



МОНГОЛ НҮҮДЭЛЧДИЙН ТАЙЛБАР ТОЛЬ-I. (2015, December 19). Мах борцлох арга [Photograph]. ikon.mn. <https://ikon.mn/n/mhh>



МОНГОЛ НҮҮДЭЛЧДИЙН ТАЙЛБАР ТОЛЬ-I. (2015, December 19). Мах борцлох арга [Photograph]. ikon.mn. <https://ikon.mn/n/mhh>



МОНГОЛ НҮҮДЭЛЧДИЙН ТАЙЛБАР ТОЛЬ-I. (2015, December 19). Мах борцлох арга [Photograph]. ikon.mn. <https://ikon.mn/n/mhh>



Монгол нүүдэлчдийн тайлбар толь II боть. (2016, May 4). Мах шуузлах арга [Photograph]. ikon.mn. <https://ikon.mn/n/q9b>

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Meat dishes

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words: халуун уураар, ан агнуур, шүүсэнд, дотор, чулуу, борцлох/шуузлах, хярамцаг, хорхог/боодог, бүхэл

Монголчуудын хийдэг өвөрмөц махан хоол нь 12) _____, _____ юм. Хорхогийг хийхдээ хонь, ямааны махыг үе мөчөөр нь эвдэж жижиглэн, битүү саванд улайсгасан чулуутай хамт хийж, халуун уураар нь жигнэн болгодог. Харин боодгийг хийхдээ тарвага зэрэг зарим ангийн махыг арьсыг нь хуулалгүй, махыг нь арьсанд нь дагуулан үлдээж, ясыг нь салгаж аваад, тулман дотор нь чулуу улайсган хийж, гаднаас нь галаар шарж хийдэг хоол. Ямаагаар бас боодог хийдэг.

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians – Meat dishes

Боодог



Densmaa. (2018, January 31). Монголчуудын Уламжлалт
Хоол "Хорхог"
[Photograph]. www.vom.mn.
<http://www.vom.mn/mn/p/38955>

Хорхог



Азаяа, Т. (2010, August 2). Монгол хоол [Photograph]. gogo.mn.
<https://gogo.mn/r/74559>

Монголчуудын идээ, ундаа Foods and drinks of Mongolians – Meat dishes

Монголчууд гурил, будаа, ногоо, ургамлыг хоол хүнсэндээ өргөн хэрэглэдэг. Жишээ нь: гурилтай хоол, элдсэн гурилтай чанасан мах, будаатай шөл, будаатай хуурга, цуйван, бууз, хуушуур, банш, бантан, ногоотой шөл гэх мэт.

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 77)



Tamorlan. (n.d.). MongolianStew01 [Photograph]. mn.wikipedia.org. https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D0%BE%D0%BE%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianStew01.JPG



Vidor. (2007, March 20). MongolianBuuz [Photograph]. mn.wikipedia.org. https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D0%BE%D0%BE%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianBuuz.JPG



Vidor. (2007, June 14). mn.wikipedia.org [Photograph]. mn.wikipedia.org. https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D0%BE%D0%BE%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianKhuushuur.JPG



Vidor. (2006, July 1). Khorkhog [Photograph]. mn.wikipedia.org. https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D0%BE%D0%BE%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Khorkhog.JPG

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians

*Дасгал 3. Дараах үгсийг ашиглан холбоо үг бүтээгээрэй.
Exercise 3. Match following words to its explanation.*

- | | |
|------------|-------------|
| 1. Бууз | а. Чимхэх |
| 2. Хуушуур | б. Буцалгах |
| 3. Гурил | в. Чанах |
| 4. Будаа | г. Зуурах |
| 5. Мах | д. Агшаах |
| 6. Ногоо | е. Хайрах |
| 7. Цай | ё. Хальслах |
| 8. Банш | ж. Жигнэх |

Дасгал 4. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 4. Discuss about following questions and review your understanding

1. Монголчууд ихэвчлэн ямар улиралд малын мах, ямар улиралд ангийн мах иддэг байсан бэ?
2. Ямар маханд аминдэм ихээр агуулагддаг вэ?
3. Монголчууд махыг яаж удаан хадгалдаг вэ?
4. Хорхогийг яаж хийдэг вэ?
5. Боодгийг яаж хийдэг вэ?

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians

Гэрийн даалгавар 1
Homework 1

Мэдлэг шалгах тест

1. Монголчуудын уламжлалт аж ахуй ньмал аж ахуй юм.

А. Нүүдлийн Б. Суурин В. Хашааны Г. Уулын

2.....үхэр, хонь, ямааны хөөрүүлсэн сүүгээр бүрдэг бөгөөд зун цагт ихэвчлэн оройн хоолонд хэрэглэдэг.

А. Таргийг Б. Хоормогийг В. Ээзгийг Г. Айргийг

3. Шар тос ньихтэй учраас эрүүл мэндэд маш тустай.

А. Илчлэг Б. Нүүрс ус В. Уураг Г. Эрдэс

4. Буцалгасан айргаа хөргөж, тааран уутанд хийж шүүгээдгаргаж авна.

А. Ааруул Б. Ээзгийг В. Аарц Г. Ээдэм

5. Гүүний сүүг исгэнгаргаж авдаг.

А. Архи Б. Хоормог В. Тараг Г. Айраг

Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians

Гэрийн даалгавар 1
Homework 1

1. Намар цагт ангийн мах, өвөл цагт бэлдэж нөөцөлсөнмахаа хоол хүнсэнд ашигладаг.

A. Малын Б. Шувууны В. Загасны Г. Ангийн

2. Махыг жижиглэн чанаж идэх нь элбэг бөгөөд үүнийгмахан хоол гэдэг.

A. Бүтэн Б. Бүхэл В. Хагас Г. Хуваасан

3. Махыг удаан хадгалах уламжлалт арга нь,.....юм.

A. Борцлох, шуузлах Б. Чанах, жигнэх

В. Чанах, жигнэх Г. Давслах, утах

4. Монголчууд мал болондотор махыг ч хоол хүнсэндээ хэрэглэнэ.

A. Малын Б. Шувууны В. Загасны Г. Ангийн

5. Монголчуудын хорхог, боодог хийдэг гол арга нь улайсгасан.....юм.

A. Мод Б. Чулуу В. Төмөр Г. Аргал

Монголчуудын идээ, ундаа Foods and drinks of Mongolians

Гэрийн даалгавар 2 Homework 2



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- *Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.
Memorize vocabulary in the given topic*
- *Өөрийн орны идээ, ундааны талаар бичээрэй.
Write about the foods and drinks in your country*

НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Мөнхцэцэг, Г., Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Баттулга, Ч (2020). Монгол орон судлал. Улаанбаатар: Удам соёл ХХК.

Admin. (2022, January 9). Монгол хоол хүнс [Photograph]. zarig.mn.

<https://zarig.mn/v2r>

Цагаан идээ [Photograph]. (2011, December 3). mn.wikipedia.org.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%A6%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BD_%D0%B8%D0%B4%D1%8D%D1%8D#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Tsagaan_idee_olon.jpg

Уламжлалт анагаах ухаан сонин. (2022, January 17). Шар тос [Photograph]. www.mnb.mn.

<https://www.mnb.mn/i/254560>

mn.wikipedia.org. (2017, July 12). Айраг [Photograph]. www.mnb.mn.

<https://www.mnb.mn/i/180033>

Mongolian national broadcaster. (2021, April 5). Хоормор [Photograph]. www.mnb.mn.

<https://www.mnb.mn/i/233008>

Бяслаг [Photograph]. (2011, October 24). mn.wikipedia.org.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%91%D1%8F%D1%81%D0%BB%D0%B0%D0%B3#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Cheese_platter.jpg

МОНГОЛ НҮҮДЭЛЧДИЙН ТАЙЛБАР ТОЛЬ-I. (2015, December 19). Мах борцлох арга [Photograph]. ikon.mn.

<https://ikon.mn/n/mhh>

НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Монгол нүүдэлчдийн тайлбар толь II боть. (2016, May 4). Мах шуузлах арга [Photograph]. ikon.mn.

<https://ikon.mn/n/q9b>

Densmaa. (2018, January 31). Монголчуудын Уламжлалт Хоол "Хорхор" [Photograph]. www.vom.mn.

<http://www.vom.mn/mn/p/38955>

Аззаяа, Т. (2010, August 12). Монгол хоол [Photograph]. gogo.mn Tamorlan. (n.d.). MongolianStew01 [Photograph]. mn.wikipedia.org.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D0%BE%D0%BE%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianStew01.JPG

Vidor. (2007, March 20). MongolianBuuz [Photograph]. mn.wikipedia.org.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D0%BE%D0%BE%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianBuuz.JPG

Vidor. (2007, June 14). mn.wikipedia.org [Photograph]. mn.wikipedia.org.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D0%BE%D0%BE%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianKhuushuur.JPG

Vidor. (2006, July 1). Khorkhog [Photograph]. mn.wikipedia.org.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D0%BE%D0%BE%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Khorkhog.JPG


Монголчуудын идээ, ундаа
Foods and drinks of Mongolians

Анхаарал хандуулсанд
баярлалаа.



https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413

Дараагийн хичээл
хүртэл баяртай!



<https://thenounproject.com/icon/lecture-1525984/>